


МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 12 сарын 30 өдөр

Дугаар A/813

Улаанбаатар хот

Г Журам батлах тухай Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллага болон шатлал хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх журмыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалыг хэрэгжүүлж, эмнэлэгт үйлчлүүлэгчийг шилжүүлэх маягтыг цахим болгох бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг анхан болон лавлагaa шатлалын эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.


3. Эмнэлэгт үйлчлүүлэгчийг шилжүүлэх үйл ажиллагаа цахимд шилжсэнтэй холбогдуулан эрүүл мэндийн байгууллага хоорондын цахим шилжилтийн програм хангамжийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Бодлого-Төлөвлөлтийн газар /Б.Буяントогтох/-т, Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тасралтгүй байдалд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний газар /Ж.Нарангэрэл/-т тус тус даалгасугай.

4. Тушаалыг 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2018 оны "Журам батлах тухай" А/256 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

С.ЭНХБОЛД



141220608

Эрүүл мэндийн сайдын...2021
оны 12 дугаар сарын 30.-ны өдрийн
#813 тушаалын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА БОЛОН ШАТЛАЛ ХООРОНД ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Анхан шатлалын эрүүл мэндийн байгууллагаас лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад үйлчлүүлэгч илгээх, буцаан хүлээн авах, өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллага хооронд үйлчлүүлэгч шилжүүлэх, эргэх холбоо тогтоох харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журмын зорилго нь тусламж, үйлчилгээг зохистой шатлалд нь үзүүлэх, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, оношилгоо, шинжилгээний давхардлыг арилгах, салбарын үр ашгийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн байгууллага хооронд үйлчлүүлэгч шилжүүлэх үр дүнтэй механизмыг бий болгоход оршино.

1.3. Эрүүл мэндийн шатлал болон байгууллага хооронд үйлчлүүлэгч шилжүүлэхдээ мэдээллийн цахим технологи “Цаг товлох үйлчилгээ”-г ашиглан амбулаторийн үзлэгийн цаг, орны хүлээгдлийн мэдээг үндэслэн эрүүл мэндийн байгууллага хооронд үйлчлүүлэгч шилжүүлэх үйл явц зохицуулагдана.

1.4. Эрүүл мэндийн шатлал болон байгууллага хооронд үйлчлүүлэгч шилжүүлэх үйл явцад дараах зарчмыг баримтална.

1.4.1. Анхан шатлалд оношлох, эмчлэх боломжтой тохиолдлыг лавлагаа шатлал руу шилжүүлэхээс зайлсхийх замаар лавлагаа шатлалын ажлын ачааллыг зохиомлоор нэмэгдүүлэхгүй байх, салбарын нөөцийг үр ашигтай зарцуулах

1.4.2. Эрүүл мэндийн байгууллага хооронд үйлчлүүлэгч шилжүүлэх үйл явц нь үйлчлүүлэгчид хүндрэл учруулахгүй байх,

1.4.3. Үйлчлүүлэгчид үзүүлсэн тусламж, үйлчилгээний мэдээллийг илгээсэн эрүүл мэндийн байгууллагад буцаан мэдээлж, эргэх холбоо тогтоох замаар тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах

1.4.4. Эрүүл мэндийн байгууллагууд үйлчлүүлэгч шилжүүлэх үедээ давхардсан оношилгоо, шинжилгээ хийхээс аль болох татгалзах.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

2.1. “Шилжүүлэх” гэж эрүүл мэндийн байгууллага болон шатлал хооронд үйлчлүүлэгчийг эмнэлзүйн заавар, журамд үндэслэн оношилгоо, шинжилгээ, үзлэг, эмчилгээ хийлгэхээр шилжүүлэх үйлчилгээг;

2.2. “Цаг товлох” гэж үйлчлүүлэгчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлэг, кабинет, эмчийн цагийг товлох;

2.3. "Эргэх холбоо тогтоох" гэж шилжүүлэн авсан үйлчлүүлэгчид үзүүлсэн тусlamж, үйлчилгээний талаарх мэдээллийг илгээсэн эрүүл мэндийн байгууллагад буцаан хүргүүлэх;

Хоёр. Тусlamж, үйлчилгээний шатлал хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх

2.1. Анхан шатнаас лавлагаа шатлалд үйлчлүүлэгчийг шилжүүлэх зохицуулалт

2.1.1. Анхан шатны эрүүл мэндийн байгууллага нь эмнэлгийн мэргэшсэн тусlamж, үйлчилгээ шаардлагатай үйлчлүүлэгчийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад шилжүүлэх, эргэх холбоо тогтоо замаар тусlamж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ;

2.1.2. Анхан шатны эрүүл мэндийн байгууллага нь энэхүү журмын 2.1.6-д зааснаас бусад тохиолдолд холбогдох эмнэлзүйн заавар, стандарт, журмын дагуу лавлагаа шатлалд үйлчлүүлэгчийг шилжүүлнэ.

2.1.3. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас лавлагаа шатлалд шилжүүлэхдээ "Эмнэлэгт өвчтөн илгээх хуудас АМ-13А маягт"-г бүрэн бөглөж илгээнэ.

2.1.4. Үйлчлүүлэгчид "Эмнэлэгт өвчтөн илгээх хуудас АМ-13А маягт"-ыг цахимаар илгээх бөгөөд мөн хэвлэж өгч болно.

2.1.5. Анхан шатны эрүүл мэндийн байгууллага нь лавлагаа шатлалд үйлчлүүлэгчийг шилжүүлэхдээ дараах байдлаар "Цаг товлох үйлчилгээ"-г үзүүлнэ.

2.1.5.1. Үйлчлүүлэгчийг лавлагаа шатлалд шилжүүлж байгаа анхан шатлалын эрүүл мэндийн байгууллага нь илгээх эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээний төрөл, чиглэл, онцлог, байршил, орны болон амбуulatorийн үзлэгийн хүлээгдэл, Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газартай гэрээтэй эсэх болон бусад мэдээллээр хангаж, үйлчлүүлэгчид эмнэлгийг сонгоход нь туслалцаа үзүүлнэ.

2.1.5.2. Үйлчлүүлэгч нь үзлэгийн товыг өөрчлөх болон цуцлах бол үйлчилгээ авахаас 8-12 цагийн өмнө "Цаг товлох үйлчилгээ"-тэй холбогдон товлолыг өөрчилж болох тухай мэдээлэл өгнө.

2.1.6. Дараах тусlamж, үйлчилгээг авах тохиолдолд үйлчлүүлэгч лавлагаа шатлалд шилжүүлэх маягтгүй шууд очиж болно. Үүнд:

- 2.1.6.1. Яаралтай тусlamж
- 2.1.6.2. Гэмтлийн тусlamж, үйлчилгээ
- 2.1.6.3. Мэс заслын тусlamж, үйлчилгээ
- 2.1.6.4. Нүдний өвчний тусlamж, үйлчилгээ
- 2.1.6.5. Чих, хамар хоолойн өвчний тусlamж, үйлчилгээ
- 2.1.6.6. Халдварт өвчний тусlamж, үйлчилгээ
- 2.1.6.7. Шүдний тусlamж, үйлчилгээ
- 2.1.6.8. Арьс, харшлын өвчний тусlamж, үйлчилгээ
- 2.1.6.9. Сэтгэцийн өвчний тусlamж, үйлчилгээ
- 2.1.6.10. Хорт хавдрын хяналтын үзлэг, шинжилгээ
- 2.1.6.11. Гемодиализын тусlamж үйлчилгээ
- 2.1.6.12. Уламжлалт анагаах ухааны тусlamж, үйлчилгээ

2.2. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагаас анхан шатны эрүүл мэндийн байгууллагад буцаан шилжүүлэх зохицуулалт

- 2.2.1. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага нь тусламж, үйлчилгээ үзүүлсний дараа “Эмнэлэгт өвчтөн илгээх хуудас АМ-13Б маягт”-ыг бүрэн бөглөж үйлчлүүлэгчийг илгээсэн анхан шатны эрүүл мэндийн байгууллагад цахимаар илгээнэ.
- 2.2.2. Үйлчлүүлэгчид “Эмнэлэгт өвчтөн илгээх хуудас АМ-13Б маягт”-ыг цахимаар илгээх бөгөөд мөн хэвлэж өгч болно.

Гурав. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх зохицуулалт

3.1. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага нь бусад лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага руу үйлчлүүлэгч шилжүүлэхдээ “Эмнэлэгт иргэнийг илгээх цахим бүртгэлийн маягт АМ-13В маягт”-ыг “Илгээх хэсэг”-ийг бүрэн бөглөж илгээнэ.

3.2. Хэвтүүлэн эмчлүүлж байгаа үйлчлүүлэгчийг шилжүүлэхдээ хүлээн авах эрүүл мэндийн байгууллагатай зөвшилцсөний дараа шилжүүлнэ.

3.3. Хүлээн авсан эрүүл мэндийн байгууллага нь “Эмнэлэгт иргэнийг илгээх цахим бүртгэлийн маягт АМ-13В маягт”-ын үйлчлүүлэгчийг “Хүлээн авах” хэсгийг бүрэн бөглөж хүлээн авна.

3.4. Хэрэв эрүүл мэндийн байгууллага үйлчлүүлэгчийг хүлээн авахаас татгалзсан бол “Цаг товлох үйлчилгээ”-нд мэдэгдэнэ.

Дөрөв. Эрүүл мэндийн байгууллага хоорондын тусламж, үйлчилгээг зохицуулах журмын оролцогч талуудын хүлээн үүрэг

4.1. Анхан шатны эрүүл мэндийн байгууллага

4.1.1. Анхан шатны эрүүл мэндийн байгууллага нь шатлал хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх үйл ажиллагааны тусламж, үйлчилгээг цахим хэлбэрээр хийх нөхцөлийг бүрдүүлж ажиллана.

4.1.2. Анхан шатны эрүүл мэндийн байгууллага нь лавлагаа шатлал руу илгээсэн үйлчлүүлэгчийн мэдээлэл, лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн маягтын мэдээллийн сан үүсгэж, шаардлагатай тусламж, үйлчилгээг тасралтгүй үзүүлэх арга хэмжээ авна.

4.2. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага

4.2.1. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад цаг товлогдон хүлээн авсан үйлчлүүлэгчид тухайн цагт нь чирэгдэлгүй тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

4.2.2. Хэрэв үйлчлүүлэгч амбулаторийн кабинет хооронд шилжин тусламж, үйлчилгээ авах тохиолдолд түүний цаг товтолыг тухайн өдөрт нь багтаан хийж, тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

4.2.3. Товлосон үзлэгийн кабинетийн эмчийн үзлэг хойшлогдсон тохиолдолд үйлчлүүлэгчид утсаар мэдэгдэнэ.

4.3. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар

4.3.1. Эрүүл мэндийн байгууллага хооронд үйлчлүүлэгч шилжүүлэх зохицуулалтын үр дүнг хянаж-шинжлэх, үнэлэх шалгур үзүүлэлтийн дагуу харьяа орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын үйлчлүүлэгч шилжүүлсэн байдалд үнэлгээ өгч ажиллана.

4.3.2. Үнэлгээний үр дүнг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зохион байгуулалт, төвлөрлийг бууруулах, төлөвлөлт, салбарын санхүүжилтийн бодлоготой уялдуулан сайжруулахад ашиглана.

4.4. Эрүүл мэндийн хөгжлийн төв

4.4.1. Эмнэлэг хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэхтэй холбоотой мэдээллийн санг үүсгэж Эрүүл мэндийн яамыг нотолгоо бүхий мэдээллээр хангана.